



**МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А/498

Ховд


**Хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 5/07 дугаар тогтоол, "Аймгийн 2022 оны төсөв батлах тухай тогтоолыг" тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Олон угсаатны өв соёлыг өвлүүлэн хөгжүүлэх" аяны хүрээнд 1000 уртын дууч бэлтгэх арга хэмжээний хүрээнд сумдаар явах сургалт зохион байгуулах зардалд нэмэлтээр 4.000.000, "Цайны зам" өв соёлын наадмаар тоглогдох Тунгалаг Буянт, Жалам хар уран бүтээлүүдийн хөгжмийн найруулгын зардал 1.000.000 төгрөг нийт 5.000.000. төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 5.000.000 төгрөг (таван сая)-ийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний 4.8 -д тусгагдсан арга хэмжээнээс тооцож санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Б.Даваадорж) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч(Т.Дэлгэрсайхан)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 2503  
Zan A/498 Tum